

ШУА-ИЙН ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ Б.ЭНХТҮВШИНГИЙН ХЭЛСЭН ҮГ

Эрхэм нөхөд өө: Та бүхний энэ өдрийн амрыг айлтгая.

Нэгэн мэргэн ухаантан “Очигдрийг мартаж болохгүй яагаад гэвэл тэр нь өнөөдрийн ч маргаашийн ч багш” гэж зөвлөж хэлсэн байдаг. Түүн лүгээ адил өнгөрсөн, одоо, ирээдүй гэсэн 3 цагийн эргэлт, тэдгээрийн хоорондын уялдаа холбоо, харилцан шүтэлцээнд нь аливаа түүхэн үйл явдал, алив түүхэн хүний ажил үйлсийг авч үзвээс жинхэнэ шинжлэх ухааны үнэн арга зүй, жинхэнэ бодитой гаргалгаа болдог билээ. Эл үүднээс авч үзхүл эрдэмтэн академич Ч.Далайн амьдралын туулсан зам, эрдмийн их бүтээл туурвил үнэхээр бахархан бахадууштай, үеийн үед дуурсан дурсагдах яруу алдарын оргил манлай юмаа. Энэ их эрдэмтний монголын түүхийн шинжлэх ухаанд оруулсан үнэт хувь нэмэр аугаа их юм. Тэрбээр улс эх орондоо ажил хөдөлмөр эрхэлсэн 54 жилийн 42-ыг Монгол Улсын шинжлэх ухааны төв байгууллага-Академийн түүхийн хүрээлэн, Дорно дахины хэлтэс, хүрээлэн, Зүүн Хойд Ази судлалын төв, Олон улс судлалын хүрээлэнгийн захирал, зөвлөхөөр тасралтгүй ажиллаж иржээ.

Академич Ч.Далай нь Монгол Улсын түүхийг цувралаар авч үзэн судлан боловсруулж дорвитой бүтээлүүд туурвисан чадварлаг түүхч эрдэмтэн хүн. Тухайлбал, “Хамаг Монгол Улс (1101-1206)”, “Их Монгол Улс (1206-1260)”, “Монголын түүх: Монголын Юан гүрэн (1260-1388)” гэсэн гурван боть бүтээлийг туурвиж нийтийн хүртээл болгосон билээ. Монгол Улсын түүхийн нэн сонирхолтой, хамгийн бахархалтай бөгөөд үүний хамт эдүгээ нэн төвөгтэй, хэн хүн сонгон авч чадаагүй тэр түүхэн үе буюу 12-р зуунаас хойших 300-гаад жилийн урт түүхийг анх түрүүн судлаж нөр их хүч хөдөлмөр, эрдэм ухаан гарган ажиллаж эдгээр бүтээлүүдийг туурвисан манай улсын дундад зууны үеийн түүхийн тулгын гурван чулууг анхлан тавьсан гавъяатай эрдэмтэн мөн билээ. Түүнээс хойш манай улсын ба гадаадын олон олон эрдэмтэн судлаач нар дээрх түүхэн үеүүдийг үргэлжлүүлэн судалсаар, баяжуулж бататгасаар явна. Өөрөөр хэлбэл, энэ аугаа эрдэмтний эхлүүлсэн энэ хэрэг буюу асаасан гал голомтыг нь бөхөөлгүй улам бадрааж цогцлоож явна. Миний дээр дурьдсан гурван боть бүтээлээс гадна академич Ч.Далай агсан “Монголын бөө мөргөлийн түүх”, “Ойрад Монголын түүх” хоёр боть, “Монгол-Хятадын харилцаа (1949-1984)”, “Монгол-Солонгосын эртний харилцаа”, “Монгол-Японы эртний харилцаа” зэрэг нэгэн зэрэг сэдэвт 10 гаруй зохиол, эрдэм шинжилгээний 240 гаруй өгүүлэл бичиж нийтийн хүртээл болгосон байх юм. Эдгээрээс “Монголын бөө мөргөлийн түүх”, “Монгол дахь хятад судлал” хэмээх бүтээлүүд нь хятад хэлээр БНХАУ-д, “Монголия XIII-XIV веках”, “Монголо-Китайские отношения” гэдэг зохиолууд нь орос, япон, чех хэлээр тухайн орнуудад орчуулагдан хэвлэгдсэнээс гадна эрдэм шинжилгээний 60 гаруй өгүүлэл, илтгэл нь англи, орос, хятад, япон, солонгос зэрэг хэлээр нийтлэгджээ. Монголын түүхийн болон орчин үеийн

олон улс судлалын чиглэлээр 25 хүнийг шинжлэх ухааны болон боловсролын докторын зэрэг амжилттай хамгаалуулсны 12 нь Орос, Хятад, Япон, Солонгос, Чех зэрэг гадаадын иргэд байна. Академич Ч.Далай тэргүүлэх сайн эрдэмтэн төдийгүй эрдмийн байгууллагуудын үйл ажиллагааг чадмаг сайн удирдан зохион байгуулагч, сайн профессор, сайн дипломатч байсныг бид бүхэн сайн мэдэх юм.

Улсдаа төдийгүй дэлхийд нэрд гарсан алдар хүндтэй, арвин их бүтээл туурвилтай энэ их эрдэмтний эрдмийн бүтээлүүдийн үнэ цэнэ, шинэлэг дорвилог санаа дүгнэлт, гаргалгаануудын талаар би энд тодорхой ярьж үнэлж дүгнэхийг бодсонгүй. Учир нь та бүхэн энэ талаар эрдмийнхээ хуралд илтгэж, дэлгэрэнгүй тодорхой ярьж санал бодлоо солилцох нь дамжиггүй.

Та бүхний эрдмийн хуралд амжилт хүсье.